



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/05 ЧАГ-САГ/2014/02/СТГА-ТШЗ

Төсвийн орлого болгох тухай

Баянзүрх дүүргийн Нийгмийн Халамж үйлчилгээний хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2013 оны 8 дугаар сарын цалингийн зардлаас нэр бүхий 4 ажилтанд 3883,5 мянган төгрөгийг гарган буцалтгүй тусламж болгон олгосон нь Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2013 оны "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т "Төсвийн байгууллага энэ журмын 3.1.4-т заасан үндэслэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хоорондзохицуулалтын хүсэлт гаргаж болно", Сангийн сайдын 2010 оны 48 тоот тушаалын 3 дугаар зүйлийн 3.2 т"цалин хөлс, нэмэгдэл урамшил, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламж болон бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох тэтгэмжийн зардлуудад ямар нэгэн зохицуулалт хийхгүй, зөвхөн батлагдсан төсвийн хуваарийг баримтална" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зориулалт бусаар зарцуулж буцалтгүй тусламжид олгосон 3883,5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж Төрийн сан дахь УАГ-ын 900000601 тоот дансанд 2014 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төвлөрүүлэн, төсвийн орлого болгох
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2014 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн дарга З.Үүрцайх, нягтлан бодогч Ө.Мэндбаяр нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор


Д.Ганбилэг
"Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК-ний
Захирал **УХА0122**
Г.Энхмаа

ЗӨВШӨӨРСӨН:
Баянзүрх дүүргийн нийгмийн халамж
үйлчилгээний хэлтсийн дарга


З.Үүрцайх
Нягтлан бодогч 
Ө.Мэндбаяр
